**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/30/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.23 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 15
**4.1 Ерөнхий зүйл** ..... 15
**4.2 Материаллаг байдал** ..... 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 16
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 17
**5.1 Төлбөрийн акт** ..... 17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024. 02. 19 № 2/07

танай____________-ны № ____________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Нийгмийн даатгалын мэдээнд 87.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, Бараа үйлчилгээний бусад зардлаас "БИ АМ ЭМ БИ" ХХК руу 2023.08.03-ний өдөр 2,371.0 мянган төгрөгийг шилжүүлэн засвар үйлчилгээ болон тавилга эд хогшил худалдан авсан нь Сангийн сайдын 2021оны 190 дүгээр тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг зөрчсөн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн

5020308

толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 85 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,742,700.00** | **10,756,939.00** |
| **33** | **АВЛАГА** | 400,000.00 | 1,427,300.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 400,000.00 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 0.00 | 1,427,300.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 0.00 | 1,427,300.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 7,342,700.00 | 9,329,639.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 280,000.00 | 1,688,300.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 280,000.00 | 1,688,300.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,062,700.00 | 7,641,339.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,548,500.00 | 1,257,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,514,200.00 | 3,944,199.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 0.00 | 1,434,290.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 1,004,950.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 53,788,771.14 | **57,912,947.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 53,788,771.14 | 57,912,947.67 |
| **392** | **Биет хөрөнгө** | 49,088,771.14 | 56,412,947.67 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 37,928,500.00 | 40,340,150.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (4,129,899.90) | (11,418,142.86) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,061,301.00 | 30,233,101.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (771,129.96) | (2,742,160.47) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 4,700,000.00 | 1,500,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,700,000.00 | 1,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **61,531,471.14** | **68,669,886.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **157,800.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 157,800.00 | 0.00 |
| **413** | **Өглөг** | 157,800.00 | 0.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 67,800.00 | 0.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 90,000.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 90,000.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **61,373,671.14** | **68,669,886.67** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 61,373,671.14 | 68,669,886.67 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 61,373,671.14 | 68,669,886.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 0.00 | 61,373,671.14 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 61,373,671.14 | 7,296,215.53 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **61,531,471.14** | **68,669,886.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **280,724,301.00** | **411,279,188.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **34,059,801.00** | **906,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 34,059,801.00 | 906,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34,059,801.00 | 906,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 34,039,801.00 | 906,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **246,664,500.00** | **410,372,288.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 212,616,500.00 | 328,249,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,616,500.00 | 328,249,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,048,000.00 | 81,438,650.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,298,000.00 | 22,384,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,750,000.00 | 59,020,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 34,650.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 684,038.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 0.00 | 684,038.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **219,350,629.86** | **397,744,344.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **219,350,629.86** | **397,744,344.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 178,335,697.15 | 369,488,261.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 122,256,218.29 | 201,244,440.00 |
| 210101 | Үндсэн цалин | 88,081,811.58 | 123,317,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 13,371,918.00 | 44,096,567.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,995,000.00 | 19,790,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,807,488.71 | 11,578,334.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 2,462,439.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,203,998.00 | 24,751,611.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,026,784.81 | 17,071,280.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,044,303.18 | 2,008,385.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 835,441.93 | 1,606,708.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 208,860.25 | 367,581.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,088,607.83 | 3,697,655.35 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 11,070,006.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 1,698,053.00 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 8,203,297.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 1,168,656.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,340,451.00 | 16,261,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 5,301,850.00 | 2,778,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,620,000.00 | 9,090,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 806,451.00 | 803,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 70,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,612,150.00 | 3,518,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 6,512,110.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 6,512,110.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,700,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,700,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,534,000.00 | 76,555,638.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,534,000.00 | 75,871,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 684,038.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,301,029.86 | 33,092,855.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 23,189,910.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,901,029.86 | 9,902,945.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 41,014,932.71 | 28,256,082.57 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 26,040,135.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 23,300,135.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 2,740,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 40,814,932.71 | 2,215,947.57 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 40,814,932.71 | 2,215,947.57 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **61,373,671.14** | **13,534,843.92** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 0.00 | 6,238,628.39 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | 372,628.39 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0.00 | 5,866,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | (6,238,628.39) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **61,373,671.14** | **7,296,215.53** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **246,684,500.00** | **410,372,288.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,000.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,000.00 | 0.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 20,000.00 | 0.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **246,664,500.00** | **410,372,288.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 212,616,500.00 | 328,249,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,616,500.00 | 328,249,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,048,000.00 | 81,438,650.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,298,000.00 | 22,384,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,750,000.00 | 59,020,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 34,650.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 684,038.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 0.00 | 684,038.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **222,034,500.00** | **390,571,138.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **222,034,500.00** | **390,571,138.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **181,019,567.29** | **362,315,055.43** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 122,566,218.29 | 202,361,740.00 |
| 210101 | Үндсэн цалин | 90,014,071.04 | 124,434,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 13,371,918.00 | 44,096,567.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,372,740.54 | 19,790,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,807,488.71 | 11,578,334.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 2,462,439.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,203,998.00 | 24,751,611.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,026,784.81 | 17,071,280.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,044,303.18 | 2,008,385.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 835,441.93 | 1,606,708.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 208,860.25 | 367,581.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,088,607.83 | 3,697,655.35 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 11,070,006.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 1,698,053.00 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 8,203,297.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 1,168,656.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,199,901.00 | 5,968,799.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,038,600.00 | 2,488,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,202,000.00 | 590,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 806,451.00 | 803,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 70,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 152,850.00 | 2,016,099.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 7,946,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 7,946,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,883,750.00 | 102,569,488.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,883,750.00 | 101,885,450.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 684,038.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,165,700.00 | 7,647,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,165,700.00 | 7,647,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,014,932.71** | **28,256,082.57** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 26,040,135.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 23,300,135.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 2,740,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 40,814,932.71 | 2,215,947.57 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 40,814,932.71 | 2,215,947.57 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **24,650,000.00** | **19,801,150.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **24,650,000.00** | **19,801,150.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **24,650,000.00** | **19,801,150.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 24,650,000.00 | 19,801,150.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 24,650,000.00 | 19,801,150.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(24,650,000.00)** | **(19,801,150.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 61,373,671.14 | 0.00 | 61,373,671.14 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **61,373,671.14** | **0.00** | 61,373,671.14 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **61,373,671.14** | **0.00** | 61,373,671.14 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **61,373,671.14** | **0.00** | 61,373,671.14 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 7,296,215.53 | 0.00 | 7,296,215.53 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **68,669,886.67** | **0.00** | 68,669,886.67 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэмнэлт, хэтрэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 328,249,600.00 | 326,033,652.43 | 2,215,947.57 | 99.32 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 328,249,600.00 | 326,033,652.43 | 2,215,947.57 | 99.32 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 302,189,100.00 | 299,993,517.43 | 2,195,582.57 | 99.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 202,487,400.00 | 202,361,740.00 | 125,660.00 | 99.94 |
| 210101 | Үндсэн цалин | 124,434,400.00 | 124,434,400.00 | - | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 45,081,600.00 | 44,096,567.00 | 985,033.00 | 97.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,234,000.00 | 19,790,000.00 | 1,444,000.00 | 93.20 |
| 210104 | Урамшуулал | 8,737,400.00 | 11,578,334.00 | (2,840,934.00) | 132.51 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,000,000.00 | 2,462,439.00 | 537,561.00 | 82.08 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,864,200.00 | 24,751,611.91 | 1,112,588.09 | 95.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,707,900.00 | 17,071,280.10 | 636,619.90 | 96.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,038,800.00 | 2,008,385.90 | 30,414.10 | 98.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,630,900.00 | 1,606,708.68 | 24,191.32 | 98.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 407,900.00 | 367,581.88 | 40,318.12 | 90.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,078,700.00 | 3,697,655.35 | 381,044.65 | 90.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,988,700.00 | 11,070,006.52 | 918,693.48 | 92.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,602,200.00 | 1,698,053.00 | (95,853.00) | 105.98 |
| 210302 | Түлш, халаалт | 9,457,300.00 | 8,203,297.52 | 1,254,002.48 | 86.74 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 929,200.00 | 1,168,656.00 | (239,456.00) | 125.77 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,981,900.00 | 5,968,799.00 | 13,101.00 | 99.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,488,300.00 | 2,488,250.00 | 50.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 590,100.00 | 590,100.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 814,700.00 | 803,550.00 | 11,150.00 | 98.63 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,800.00 | 70,800.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,018,000.00 | 2,016,099.00 | 1,901.00 | 99.91 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,946,400.00 | 20,946,400.00 | - | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| 210602 | Тавилга | 8,000,000.00 | 8,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,946,400.00 | 7,946,400.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 24,953,500.00 | 24,947,950.00 | 5,550.00 | 99.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,953,500.00 | 24,947,950.00 | 5,550.00 | 99.98 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,967,000.00 | 9,947,010.00 | 19,990.00 | 99.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,967,000.00 | 9,947,010.00 | 19,990.00 | 99.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,060,500.00 | 26,040,135.00 | 20,365.00 | 99.92 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,060,500.00 | 26,040,135.00 | 20,365.00 | 99.92 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,300,200.00 | 23,300,135.00 | 65.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,760,300.00 | 2,740,000.00 | 20,300.00 | 99.26 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 328,249,600.00 | 326,033,652.43 | 2,215,947.57 | 99.32 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 328,249,600.00 | 326,033,652.43 | 2,215,947.57 | 99.32 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 328,249,600.00 | 326,033,652.43 | 2,215,947.57 | 99.32 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **32,733,000.00** | **79,038,650.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **32,733,000.00** | **79,038,650.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 32,733,000.00 | 79,038,650.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 28,958,000.00 | 79,038,650.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,958,000.00 | 79,038,650.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,775,000.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,775,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 32,733,000.00 | 79,038,650.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 32,733,000.00 | 79,038,650.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,298,000.00 | 19,984,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 30,435,000.00 | 59,020,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 34,650.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Соёл урлагийн газар нь “Төрөөс баримтлах соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн онцлог хэв шинж бүхий соёлын өвд тулгуурлах хүн амыг соён гэгээрүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оршино” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус байгууллага нь Соёлын яамнаас дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Соёл, урлагийн хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтэс гэсэн зохион байгуулалттай, төрийн гүйцэтгэх 9, төрийн үйлчилгээний 2, нийт 11 орон тоотой үйл ажиллагаа явуулжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,138.4 мянган төгрөг буюу 17.2 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 7,742.7 | 10,756.9 | 3,014.2 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 400.0 | 1,427.3 | 1,027.3 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 7,342.7 | 9,329.6 | 1,986.9 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 53,788.8 | 57,912.9 | 4,124.2 |
| Үндсэн хөрөнгө | 58,689.8 | 72,073.3 | 13,383.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (4,901.0) | (14,160.3) | (9,259.3) |
| **Нийт хөрөнгө** | 61,531.5 | 68,669.9 | 7,138.4 |
| Өр төлбөр | 157.8 | 0.0 | (157.8) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 61,373.7 | 68,669.9 | 7,296.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 61,531.5 | 68,669.9 | 7,138.4 |

Авлагын дансны үлдэгдэл 1,427.3 мянган төгрөг байгаа нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдож төлбөрийн актыг цалингийн урьдчилгаагаар барагдуулж авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,329.6 мянган төгрөг болж 1,986.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 43,639.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, үндсэн хөрөнгийн данснаас өмнөх оны аудитаар 442.3 мянган төгрөгөөр бараа материалыг шилжүүлсэн нь үлдэгдэл өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 72,073.3 мянган төгрөг болж 13,383.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 19,801.2 мянга, Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 464.6 төгрөгийн сандал, ширээ ирсэнтэй холбоотой байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгө дутагдаж 6,440.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон ба тус дутагдсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 68,669.9 мянган төгрөг болж 7,138.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 294,760.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 294,760.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 30,821.7 мянган төгрөгөөр бууруулж 263,938.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 328,249.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 326,033.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 326,033.7 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох НДШ 1,112.6 мянга байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 918.7 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 302,189,100.00 | 299,993,517.43 | 2,195,582.57 | 99.3 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 26,060,500.00 | 26,040,135.00 | 20,365.00 | 99.9 |
| | НИЙТ | 328,249,600.00 | 326,033,652.43 | 2,215,947.57 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Соёл ,урлагийн газрын даргын 2023 оны 7-р сарын 06 өдрийн А/24 тушаалаар “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох уран бүтээлч, оролцогч нарын байрлах байрны зардалд 12,800.0 мянга Нүүдлийн эвент арга хэмжээний зардалд 5,500.0 мянга, Соёлын сайдын 2023 оны 6-р сарын 26 өдрийн А/257 тушаалаар “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг оролцуулахад шаардагдах зардал 10,000.0 мянга, Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 08-р сарын 04 өдрийн А/419, Засаг даргын 2023 оны 08-р сарын 04 өдрийн А/421 захирамжаар “Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, чадавхжуулах ажлын хүрээнд 19,984.0 мянга, Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж соёлын сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн А/253 тоот тушаалаар 19,500.0 мянга, Соёлын сайдын 2023 оны өдрийн А/427 тушаалаар 11,220,0.0 төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах бараа, ажил үйлчилгээ байргүй байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 9,457.3 мянга, гэрэл цахилгааны зардалд 1,602.2 мянга, цэвэр бохир усны зардалд 929.2 мянган төгрөг батлагдсанаас RMB XXK-тай дулаанаар хангах гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, "Чандмань-Баянхонгор"ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 328,249.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,282.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,297.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 918.7 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын асуудалд алдаа зөрчил илрээгүй.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих мэдээллийн бүрэн оруулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж аудитаар 7,727.0 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 28,950.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,237., мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 138 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 4 | 7,727.0 | 4 | 7,727.0 | 100% |
| Албан шаардлага | 1 | 28,950.0 | 1 | 28950.0 | 100 % |
| Зөвлөмж | 4 | 3,237.3 | 4 | 3,237.3 | 100 % |
| **Нийт дүн** | **9** | **39,914.3** | **9** | **39,914.3** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,400.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан нь 2,400.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 2,458.1 мянган төгрөгийн 2 зөрчил[2] илэрснээс 87.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,371.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,458.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 824.4 мянган төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Нийгмийн даатгалын мэдээнд 87.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т заасан “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна..

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Авлагаар тусгаагүй НДШ-ийн илүү төлөлт 87.1 мянган төгрөгийг суутган тооцож төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Зөвлөмж[3]

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1. Зардлын данстай холбоотой асуудал*

*<u>Илрүүлэлт:</u>* Бараа үйлчилгээний бусад зардлаас “БИ АМ ЭМ БИ” ХХК руу 2023.08.03-ний өдөр 2,371.0 мянган төгрөгийг шилжүүлэн засвар үйлчилгээ болон тавилга эд хогшил худалдан авсан нь Сангийн сайдын 2021оны 190 дүгээр тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Цаашид Сангийн сайдын 2021оны 190 дүгээр тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж ажиллах зөвлөмжийг төсөв захирагчид хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[3] Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан нь 2,400.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | 2,400.0 | | | 1 | 2,400.0 | 1 | 2,400.0 | | |
| **Дүн** | **1** | **2,400.0** | | | **1** | **2,400.0** | **1** | **2,400.0** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийгмийн даатгалын мэдээнд 87.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 1 | 87.1 | 1 | 87.1 | | | | |
| Бараа үйлчилгээний бусад зардлаас “БИ АМ ЭМ БИ” ХХК руу 2023.08.03-ний өдөр 2,371.0 мянган төгрөгийг шилжүүлэн засвар үйлчилгээ болон тавилга эд хогшил худалдан авсан. | 1 | 2,371.0 | | | | | 1 | 2,371.0 |
| **Нийт дүн** | **2** | **2,458.1** | **1** | **87.1** | | | **1** | **2,371.0** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил байхгүй. | 0 | 0 | | | 0 | 0 | | |
| Дүн | **0** | **0** | | | **0** | **0** | | |

------------oOo-------------